



## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

### Гадаадад сургалтад хамруулах тухай

Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, "МУБИС-ийн дүрэм"-ийн 4.4.1, 4.4.7 дугаар заалт, "МУБИС-ийн Хөгжлийн бодлого", МУБИС-ийн захирлын зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Америкийн Нэгдсэн Улсын Миссури Их Сургуулийн Ази судлалын төвтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд багш, судлаачдад зориулсан сургалтад 2022 оны 06 дугаар сарын 05-аас 06 дугаар сарын 25-ны хооронд хамрагдах 12 багш, мэргэжилтний бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Сургалтад хамрагдах 12 хүний байр, сургалтын төлбөр болох 42,240 (Дөчин хоёр мянга хоёр зуун дөчин мянга) ам.доллар болон замын зардлын 50% болох 38,892,000 (Гучин найман сая найман зуун ерэн хоёр мянга) төгрөгийг зохих зардлын зүйлээс санхүүжүүлэхийг Санхүү, аж ахуй эрхэлсэн дэд захирал (Д.Мөнхжаргал), Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (М.Уранжаргал), Захиргаа, аж ахуйн нягтлан бодогч (Д.Саранчимэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Сургалтын үр дүнд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал (Д.Мандах), Сургалт эрхэлсэн дэд захирал (Н.Мягмарцоож) нарт даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

*О.АЛТАНГОО*

О.АЛТАНГОО

9387792-8021051139

МУБИС-ийн захирлын 2022 оны  
03 сарын 24 өдрийн 1/65 дугаар  
тушаалын хавсралт 01

АНУ-н Миссури Их Сургуулийн Ази Судлалын Төвд 2022 оны 06-р сарын 05-  
аас 06-р сарын 25-ны хооронд багш, мэргэжилтний сургалтад хамрагдах  
бүрэлдэхүүн

№	Бүрэлдэхүүн сургууль	
1	Багшийн сургууль	Н.Үүрийнтуяа
2	Ерөнхий боловсролын сургууль	Ж.Гүррагчаа
3	Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль	О.Мягмарсүрэн
4	Математик, байгалийн ухааны сургууль	Ц.Сэр-Од
5	Биеийн тамирын сургууль	Б.Нармандах
6	Дүрслэх урлагийн, технологийн сургууль	Т.Сэлэнгэ
7	Гадаад харилцааны алба	Д.Үүрийнтуяа
8	Зайн сургалтын алба	Ц.Нямсүрэн
9	Сургуулийн өмнөх боловсролын сургууль	Н.Түвшинлхагва
10	Боловсрол судлалын сургууль	Ж.Шинэбаяр
11	Захиргаа	Н.Мягмарцоож
12	Архангайн багшийн сургууль	Б.Саранцацралт

МУБИС-ийн захирлын 2022 оны 03 сарын 24 өдрийн  
 ... дугаар тушаалын хавсралт



АНУ-н Муссури Их Сургуулийн Дээд Судлалын Төвд 2022 оны 06-р сарын 05-аас 06-р сарын 25-ны хооронд сургалт оролцох багш, мэргэжилтний зардлын төсөв

	Зардал	Нэгжийн үнэ		Хоног	Хүний тоо	Нийт	Тайлбар
		Ам. доллар	Төгрөг				
1	Сургалтын зардал	3520		21	12	42,240 ам.доллар	1 хүн 21 хоногт 3520 ам.доллар
2	Онгоцны тийз:УБ-Сэнт Луиз/Сэнт Луиз-УБ		3,241,000		12	38,892,000	1 хүн онгоцны тийзний 50% -г МУБИС хариуцна / групп хөнгөлөлт тооцсон үнэ /

Тайлбар: 2022 оны 03 сарын 23-ны өдрийн Монгол банкны ханш: 1 ам.доллар 2914,45 төгрөг